

I-V ангийн зөв бичих чадварын агуулгын залгамж холбоо

Анги	1-р анги	2-р анги	3-р анги	4-р анги	5-р анги
БИЧИХ ЧАДВАР					
Бичих чадварт тавигдах шаардлага	Үсгийг зурлагын дагуу зөв бичих, үг холбон, өгүүлбэрийг том үсгээр бичих	Үг холбон, өгүүлбэрийг том үсгээр эхлэн бичих, өгүүлбэр, эхийг бүтцийн дагуу хичээнгүй алдаагүй зөв бичих	Үг холбон, өгүүлбэрийг том үсгээр эхлэн бичих, өгүүлбэр, эхийг бүтцийн дагуу хичээнгүй алдаагүй зөв бичих	Үг холбон, өгүүлбэрийг том үсгээр эхлэн бичих, өгүүлбэр, эхийг догол мөрөөр зааглан, дагийн дагуу хичээнгүй алдаагүй зөв бичих	Үг холбон, өгүүлбэрийг том үсгээр эхлэн бичих, өгүүлбэр, эхийг догол мөрөөр зааглан, дагийн дагуу хичээнгүй алдаагүй зөв бичих
Зөв бичих	1.2.а. Хуулж болон цээжээр бичихдээ үсэг, үг, өгүүлбэрийг дагийн дагуу бичих	2.2.а. [н,г] үсгээр утга ялгах үгсийг зөв унших, нүдлэх, зөв бичих	"3.2а. Утга ялгасан үгийг /н,г,х/ зөв дуудах, нүдлэх, өгүүлбэрт утга ялган зөв хэрэглэх"	4.2а. Дуудлага ихил зарим үгийг утга, бичлэгээр нь ялгах өгүүлбэрт зөв бичих (буурь-буйр, хууль-хуйл, тууль-туйл)	5.2а. Залгавар залгахад эгшиг гээгдэх, гээгдэхгүй тохиолдлыг мэдэж, бүлэглэх, тайлбарлах
	1.2.б. Хүний нэр ба өгүүлбэрийг том үсгээр эхлэн бичих, өгүүлбэрт цэг, таслал, асуултын тэмдгийг зөв хэрэглэх	2.2.б. Эр, эм үг үгэнд "ы, ий" залгаврыг зөв залган бичих	"3.2б. Балархай эгшигийн эгшигжүүлэх үүргийг мэдэх, бичихдээ хэрэглэх"	4.2б. Балархай эгшигийн эгшигжүүлэх, зөөлрүүлэх үүргийг мэдэх, зөв бичих	5.2.б. Үйл үг бүтээх "-л" дагаврын дүрмийг мэдэх, зөв бичих
		2.2.в. Үгийг үеэр таслан мөр шилжүүлж зөв бичих	"3.2в. Дараалсан гурван гийгүүлэгчийн дүрмээр зөв бичих"	4.2в. ж, ч, ш-ийн дараа "и" бичдэгийн учрыг мэдэх, зөв бичих	
		2.2.г. Цагаан толгойн үсгийг эгшиг, гийгүүлэгч, тэмдэг үсэг гэж ангилж, бүлэглэх	3.2г. Газар ус, улс орон зэрэг оноосон нэрийг ялгах, зөв бичих	4.2г. Хатуу, зөөлний тэмдгийн тусгаарлах үүргийг мэдэж, зөв бичих	



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр.....цаг




Бичлэг болон утгаараа өөр боловч дуудлага нь ижил үгсийг ижил дуудлагатай үгс гэнэ. Жишээ нь буурь – буйр , хууль – хуйл, тууль - туйл

1 Үгсийг харьцуулан уншаад, утга ялгаж буй үгсийн доогуур зураарай.

Туул	туйл	тууль	буур	буйр	буурь
хуул	хуйл	хууль	даахь	даах	дайх

2 Зургийг ажиглаад, холбоо үгийн утгыг мэдэж аваарай. Хоёр холбоо үгийг сонгон өгүүлбэр зохиогоорой.



хойд туйл



Туул гол



үлгэр тууль



хүрэн буур



Буйр нуур



гэрийн буурь



Хуулж авах



хуйлсан цаас



хууль дүрэм

3 Цэгийн оронд тохирох үгийг бичиж, өгүүлбэрийг гүйцээгээрэй.

А. Өвөө үлгэр ярив. /туйл, тууль/

Б. голын хөвөөгөөр модод ургасан байв. /Туйл, Туул/

В. Нүүхдээ гэрийн сайн цэвэрлэх хэрэгтэй. / буйраа, бууриа/

Г. дүрмээ сайн баримтлаарай. /Хуйл, Хууль/

4 Үгсээр өгүүлбэр зохиож бичээрэй.

туйл	<div style="border-bottom: 1px dashed black; height: 20px; width: 100%;"></div> <div style="border-bottom: 1px dashed black; height: 20px; width: 100%;"></div> <div style="border-bottom: 1px dashed black; height: 20px; width: 100%;"></div>
хуул	
буур	

Дууссан:онсарөдөр.....цаг

Өөрийн үнэлгээ: 1 2 3 4



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр.....цаг



Зөөлөрсөн гийгүүлэгч

дан зөөлөрсөн
гурил, ахин

давхар зөөлөрсөн
анги, горхи



"и" балархай эгшиг нь өмнөх гийгүүлэгчээ зөөлрүүлэх үүрэгтэй.

1 А. Дараах үгсийг уншаад, балархай эгшгийг дугуйлаарай.

Б. Балархай эгшиг нь ямар үүрэгтэй вэ? Зөв харгалзуулаарай

тарив, сорив, танил, гурил, ахин

○ Дан зөөлрүүлэх үүрэгтэй

салхи, горхи, тархи, гархи, анги,

○ Давхар зөөлрүүлэх үүрэгтэй

2 Тохирох эгшгийг нөхөж бичээрэй.

Хичээл тар.в

Оюун ухаанаа сор.в

Хэрэггүй цаасыг ур.в

Цэцэг тар.в

Ундаагаа сор.в

Төрсөн өдөрт ур.в

3 Балархай эгшиг нь зөөлрүүлэх үүргээр орсон үгийг ялган бичээрэй.



урив, хөнжил, учир,
түшиг, чамин, заншил,
гурил, байшин, солир,
ажил, адил

Зөөлрүүлэх үүргээр орсон балархай эгшиг гээгдэхгүй. Жишээ нь: гурилыг

4 Урт эгшгээр эхэлсэн залгаврыг зөв залган бичээрэй.

тамир+аас, цахим+аар, анир+ыг, танил+аар, гуниг+ийг, морин+оос, охин+ы

Дууссан:онсарөдөр.....цаг

Өөрийн үнэлгээ: 1 2 3 4

Үгийн дунд орсон “ж, ч, ш”-ийн дараа балархай эгшиг “и” бичдгийг мэдье



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр..... цаг



Эр, эм ямар ч үгийн дунд орсон ж, ч, ш гийгүүлэгчийн дараа балархай эгшиг бичих шаардлага гарвал дандаа и эгшиг бичнэ. Жишээлбэл: **ажил, ашиг, ишиг, хөгжил, учир, дэвших** гэх мэт.

1 “и” эгшгийн өмнөх гийгүүлэгчийг дугуйлаарай. Ямар гийгүүлэгч байна вэ? Хоосон нүдэнд гийгүүлэгчийг нөхөж бичээрэй.

- ❖ ажил, бүжиг, хөгжил, жүжиг, ажилсаг Үгийн дунд гийгүүлэгч байна.
- ❖ ашиг, машин, дэвшил, ишиг, хашилт Үгийн дунд гийгүүлэгч байна.
- ❖ ачит, хүчит, навчит, цочих, дуучин Үгийн дунд гийгүүлэгч байна.

2 Дүрэмд тохирох үгийг ялгаж бичээрэй.



шугам, хөнжил, учир,
түшиг, шонхор,
заншил, журам,
байшин, чагнуур, ажил

Үгийн дунд “ж, ч, ш”-ийн ард “и” бичсэн үгс

3 Зөв бичсэн үгийг гэж тэмдэглээрэй.

- түшиг
- жүжэг
- үсчин
- зурагчан
- түшэг
- жүжиг
- үсчэн
- зурагчин

4 Алдаатай үгийг олж, өгүүлбэрийг зөв болгон бичээрэй.
Богшорго модны мөчөр дээр суув.

5 Цэгийн оронд тохирох балархай эгшгийг нөхөж бичээрэй.

Түүвэр өгүүлбэр

Сар гэдэг махч...н шувуу хорт...н мэр...гчийг барьж иддэг аш....гтай шувуу юм. Лонж...д гуай малаа хашаанд хаш...в. Адууч....н болох сайхан. Ууж....м сайхан талд хүч....т комбайн хүрж.....гнэнэ.

6 Дүрэмд тохирох таван жишээ бичээрэй.

Үгийн дунд “ж, ч, ш”-ийн ард “и” бичсэн үгс

Дууссан:онсарөдөр.....цаг Өөрийн үнэлгээ: 1 2 3 4 5 6

Хатуу, зөөлний тэмдгийн тусгаарлах үүргийг мэдэж, зөв бичье



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр.....цаг



Эр үгэнд я, ё эгшиг өмнөх гийгүүлэгчээсээ саланги дуудагдахаар орвол өмнө нь хатуугийн тэмдгээр тусгаарлаж бичнэ.



Эм үгэнд е эгшиг өмнөх гийгүүлэгчээсээ саланги дуудагдахаар орвол өмнө нь зөөлний тэмдгээр тусгаарлаж бичнэ.

Эгшиг болон зөөлний тэмдгээр төгссөн үгэнд я,е,ё,ю-г шууд залган бичнэ.

1 Үгсийг харьцуулан хараад, цэгийн оронд тохирох үгийг нөхөж бичээрэй.



тар+я=тар**ъ**я



тар**ь**+я=тар**ь**я



хар+я=.....



хар**ь**+я=.....



ур+я=.....



унш+я=.....

2 Цэгийн оронд **Ъ** , **Ь** аль тохирохыг бичээрэй.

ө г . е а в . я ү з . е х э л . е

б о д . ё з у р . я б у ц . я у р . я

3 Үгсийг ангилж бичээрэй.



хар**ъ**я, бод**ё**,
хэл**ь**е, суралц**ъ**я,
дэмж**ь**е, хөгж**ь**е,
арч**ъ**я, хүс**ь**е

Ъ тэмдгээр тусгаарласан үг

Ь тэмдгээр тусгаарласан үг

4 Алдаатай үгийг олж зөв болгон бичээрэй.

Самбар ар**ч**ья.

Тэмцээнд оролц**ь**ё.

Цэвэр бич**ь**е.

Дууссан:онсарөдөр.....цаг

Өөрийн үнэлгээ: **1** **2** **3** **4**

Хатуу, зөөлний тэмдгийн тусгаарлах үүргийг мэдэж, зөв бичье



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр.....цаг

1 Дүрэмд тохирох үгийг зөв харгалзуулаарай.

- харъя
- сууя
- барья
- үзье
- бодъё

- Гийгүүлэгчээр төгссөн үгэнд я,е,ё-г залгахдаа "ъ,ь" тэмдэг жийрэглэнэ.
- Эгшгээр төгссөн үгэнд я,е,ё,ю-г шууд залган бичнэ.
- Зөөлний тэмдгээр төгссөн үгэнд я,е,ё,ю-г шууд залган бичнэ.

- урья
- саная
- оръё
- хүргэе
- хүсье

2 Цэгийн оронд хаалтад байгаа үгсээс сонгон өгүүлбэрийг гүйцээж бичээрэй.

Анарыг төрсөн өдөртөө Хичээлээ тараад гэртээ.....
 Тоо бодож оюунаа..... Алсын уулсыг.....
 Бүгдээрээ мод..... Ажлаа дуусаад.....

(сорьё, урья, харья, тарья, харъя)

3 я,е,ё-г зөв залган бичээрэй.

хураа, инээ, гүй, суу, заа, сана, харь, зорь, сорь, урь, барь

бод, хар, өг, үз, зор, ур, тар, бич, хад, уулз,

4 Үгсийг ажиглаад, дүрмийг бичээрэй.



хаая, нээе,
тууя, саная,
ууя, нүүе

дүрэм

харья, барья, сольё, тарья,
урья, сорьё

Дууссан:онсарөдөр.....цаг

Өөрийн үнэлгээ: 1 2 3 4